



**НИЙСЛЭЛИЙН
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/607

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн төр захиргааны байгууллагын
үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "л", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хан-Уул дүүргийн төр захиргааны байгууллагын 2021 оны үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг нэгдүгээр, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх удирдамжийг хоёрдугаар, хороодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг гуравдугаар, ажлын хэсгийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хуулийн дагуу ил тод, шударга, хөндлөнгийн нөлөөллөөс хараат бусаар зохион байгуулж тайлагнахыг ажлын хэсгүүдэд, удирдлага, зохион байгуулалтаар ханган хяналт тавьж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т даалгасугай.

3. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж, Хяналт-шинжилгээний үнэлгээнд үндэслэн гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг бүх хэлтэс, тасаг, алба, хорооны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлагдсан төсвөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т, Санхүү, төрийн сангийн хэлтэс (М.Цогзолмаа)-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ж. АЛДАРЖАВХЛАН

1170201692

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2021 оны 1 дугаар сарын
02...-ны өдрийн 1/607 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

а/ Хан-Уул дүүргийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгдүгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Захиргааны бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Архивын арга зүйч

Нарийн бичгийн дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

б/ Хан-Уул дүүргийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хоёрдугаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн дарга

Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтын хэлтсийн дарга

Гишүүд:

Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Эрх зүйн маргаан шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн

Албан хэрэг хөтлөлт түүний зохицуулалт хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн

в/ Хан-Уул дүүргийн хороодын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гуравдугаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн дарга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Архивч

Нарийн бичгийн дарга

Хороо хариуцсан ажилтан

г/ Хан-Уул дүүргийн хороодын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дөрөвдүгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн дарга

Хууль зүйн тасгийн дарга

Гишүүд:

Мэдээллийн аюулгүй байдлын офицер

Өргөдөл гомдол, нэг цэгийн үйлчилгээний ажилтан

Нарийн бичгийн дарга

Боловсрол, соёл урлагийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар A/131

Улаанбаатар хот

**Хяналт-шинжилгээ хийх төлөвлөгөө
батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хан-Уул дүүргийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын 2021 оны үйл ажиллагааны явц, үр дүнд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, товлосон хугацаанд тайлагнахыг Ажлын хэсгүүдэд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С. ЭНХБАЯР

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын
 газрын даргын 2021 оны 12 дугаар...
 сарын 22-ны өдрийн 1/121 дүгээр...
 тушаалын хавсралт



ДҮҮРГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БҮХ ШАТНЫ БАЙГУУЛЛАГЫН
 2021 ОНЫ ҮЙ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
 ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хаиуцах албан тушаалтан
1	Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах	XI/25-30	Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэнг орлон гүйцэтгэх албан хаагч
2	Хяналт шинжилгээ үнэлгээ хийх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын захирамжаар батлуулах	XI/29-XII/01	
3	Хуваарийн дагуу хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулах	XII/01-30	Томилогдсон ажлын хэсэг
4	Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын дүн, тайланг нэгтгэх	XI/15-XII/30	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар
5	Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайланг танилцуулах	XII/20-XII/30	Ажлын хэсгийн ахлагч нар
6	Ажлын хэсгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, гарсан шийдвэрийн дагуу арга хэмжээ авах	XII сард	Дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн дарга
7	Хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх	XII/30-ны дотор	Дүн шинжилгээ хийх Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга